

170600060161




Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны
01 дүгээр сарын 19-ний өдрийн 012/2024 тоот
албан бичгийн нэгдүгээр хавсралт

Ерөнхий сайдын орон нутагт ажилласантай холбогдуулан Эрчим хүчний яаманд иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт

2024.01.19

№	Аймаг, өргөдлийн агуулга	Байгууллага иргэдийн санал, хүсэлт, гомдол	Шийдэгдсэн хэсэг	Шийдвэрлэлтийн байдлыг дэлгэрэнгүй тодорхой бичих (Шийдвэрлэсэн эсэх, шийдвэрлээгүй бол шалтгаан, иргэнд хариу хүргүүлсэн эсэх, хариуг ямар хэлбэрээр хүргүүлсэн г.м)	Утсаар холбогдох мэдээллийг өгсөн.
1	Хөвсгөл	Дулааны станц болон хатуу хучилттай замын санхүүжилтийг 2024 оны төсөвт суулгаж өгөхийг хүссэн	тийм	Өргөн баригдсан Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгагдсан.	Утсаар холбогдох мэдээллийг өгсөн.
2	Хөвсгөл	ИТХ-Төсөвт тусгах санал: Ханх сумыг Хатгал тосгонтой холбосон хатуу хучилттай авто зам, Архангай-Хөвсгөл чиглэлийг холбосон босоо тэнхлэгийн зам, Хөвсгөл дулааны станцыг өргөтгөх 2024 төсөвт суулгах	тийм	Өргөн баригдсан Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгагдсан.	Утсаар холбогдох мэдээллийг өгсөн.
3	Булган	П.Лхагва-Очирос Газрын асуудал шийдвэрлүүлэх	тийм	Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Засаг даргаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан. Эгийн голын усан цахилгаан станц төслийн хэрэгжилтийн явц болон тус төслийг хэрэгжүүлэх газартай холбоотой асуудлыг шийдвэрлэх тухай хүсэлтийн дагуу Булган аймгийн Засаг даргад 2023.11.13-ний өдрийн а/33769 албан бичиг хүргүүлсэн.	албан бичгээр
4	Увс	Б.Мөнгөнөөс Дулааны станцын ТЭЗУ, засвар, өргөтгөлийг хийх 13.6 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлэх	тийм	Эрчим хүчний сайдын 2024 оны төсвийн төсөлд тусган 2023.08.14 өдрийн а/2671 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Тухайн төсөл арга хэмжээний магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан зураг төсөв байхгүй тул Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгагдаагүй. 2023.11.01-ний өдөр иргэнд утсаар холбогдох шийдвэрийг мэдэгдсэн ойлгосон гэдгээ илэрхийлсэн.	Утсаар холбогдох мэдээллийг өгсөн.
5	Орхон	Эрдэнэт усан цэнэгт цахилгаан станц ХХК-аас Сэргээгдэх эрчим хүчний ногоон төслийн талаар	тийм	Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд "Эрдэнэт хуримтлуур УЦС төслийг Засгийн газрын хэрэгжүүлэх төслийн жагсаалтад оруулах талаар хүсэлтийг тухайлан нэр зааж оруулах боломжгүй талаар Сайдын 2023.06.12-ний өдрийн а/1982 тоот албан бичгээр хариу өгсөн.	албан бичгээр
6	Говь-Алтай	Говь-Алтай аймгийн засаг даргаас Боомтын сэргэлтийн хүрээнд	тийм	Аймгийн төвд баригдах дулааны станцын 2-р хэлхээний холболтын ус, дулаан цахилгааны шугам сүлжээ инженерийн дэд бүтцийн 24,4 тэрбум төгрөгийг төсөвт суулгах санал ирүүлсэн бөгөөд Монгол Улсын 2024 оны төсвийн хуулийн 2-р хавсралтын XVII.23-т "Аймгийн төвд баригдах байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл арга хэмжээ батлагдсан.	Утсаар холбогдох мэдээллийг өгсөн.
7	Орхон	Эрдэнэт хотын захиралчийн ажлын албанаас Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх шаардлагатай инженерийн шугам сүлжээ	тийм	35 кв-ын 2 хэлхээ тойрог схем үүсгэх хөрөнгийг 2024 оны төсөвт суулгах санал ирүүлсэн бөгөөд батлагдсан зураг төсөвтэй ажил байсан тул хасагдсан. Энэ талаар програмд зураг төсөв оруулахыг тус аймгийн холбогдох мэргэжилтэнд утсаар мэдэгдсэн.	Утсаар холбогдох мэдээллийг өгсөн.
8	Орхон	О.Алтанхуягаас Эрчим хүчний салбарын үйлдвэр компанид зөвлөхөөр ажиллах хүсэлт	тийм	Иргэний хүсэлтийг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-д Төрийн нарийн бичгийн даргын 2023.11.15-ны өдрийн а/3780 тоот албан бичгээр шилжүүлсэн бөгөөд иргэн өндөр насны тэтгэвэрт суусан байсан, компани хэмээлтийн хуулийн хүрээнд зөвлөх авч ажиллах боломжгүй байна гэдгийг өөрийнх утсаар 2023.12.04-ний өдөр холбогдох мэдэгдсэн иргэн ойлгосон гэдгээ илэрхийлсэн	Утсаар холбогдох мэдээллийг өгсөн.
Нийт					8



Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны
01 дүгээр сарын 19-ний өдрийн *Улаанбаатар* тоот албан
бичгийн хоёрдугаар хавсралт

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдөр эрчим хүчний салбарынхантай өглөөний уулзалт хийж, уулзалтаар яригдсан асуудлууд, эрчим хүчний салбарт тулгамдсан цагийн үеийн болон өвлийн бэлтгэл ажлын явцын талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг өгсөн.

1. Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанд энэ талаар Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулж, улмаар 29 дүгээр тэмдэглэлээр албан тушаалтнуудад үүрэг өгөгдсөн.

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2023.07.19-НИЙ ӨДРИЙН 29 ТЭМДЭГЛЭЛЭЭР ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН
БИЕЛЭЛТ:**

№	Даалгавар	Хэрэгжилтийн явц биелэл	Биелэлт
1	Эрчим хүчний салбарын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцын талаар 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах.	Эрчим хүчний салбарын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын гүйцэтгэл, явцын талаар танилцуулгыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт Эрчим хүчний сайдын 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн а/3185 дугаар албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанд танилцуулсан.	100%
2	Улаанбаатар хот болон Булган аймгийн Гурван булаг суманд тохиолдсон байгалийн аюулт үзэгдлийн улмаас эвдэрсэн эрчим хүчний дэд бүтцийг сэргээн босгоход шаардагдах зардлын эх үүсвэрийн талаар судалж, саналаа Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх.	Байгалийн гэнэтийн гамшигт үзэгдлийн улмаас Булган аймгийн Гурванбулаг сум, Улаанбаатар хотод үүссэн аваар саатлыг устгаж, хэвийн болгоход зарцуулсан зардлыг Засгийн газрын нөөцөөс гаргуулах тухай албан хүсэлтийг Эрчим хүчний яамны 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 6/2447 дугаар албан бичгээр Улсын Онцгой комиссын дарга бөгөөд Монгол Улсын шадар сайдад хүргүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 293 дугаар тогтоолоор байгалийн гэнэтийн гамшигт үзэгдлийн улмаас үүссэн цахилгаан дамжуулах агаарын шугамын эвдрэл, гэмтлийг засварлах, сэргээн босгох, хэрэглэгчдийг цахилгаанаар хэвийн хангахад зарцуулсан нийт 2,422.3 сая төгрөгийн санхүүжилтийг Засгийн газрын нөөц сангаас авч, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-д 31,796.0 сая төгрөгийг, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д 626.3 сая төгрөгийг хуваарилсан. Олгосон санхүүжилтээр ЦДҮС ТӨХК, УБЦТС	100%

		ТӨХК-уудын аваарийн нөөцөөс зарцуулсан бараа, материалуудын нөхөн бүрдүүлэх ажилд хяналт тавин ажилласан.	
3	Эрсдэлийг нарийвчлан тооцож, эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангахад чиглэсэн эрчим хүчний тусгай зориулалтын сэлбэг материал, тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах зардлыг 2024 оны улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авах.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангахад чиглэсэн эрчим хүчний тусгай зориулалтын сэлбэг материал, тоног төхөөрөмж худалдан авахтай шаардагдах 4.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг батлуулсан.	100%
4	"Тавантолгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх, нөөцлөхөд 2024 онд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авч ажиллах.	"Таван толгой түлш" ХХК-ийн 2024 оны бизнес төлөвлөгөөг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцэн баталсан бөгөөд 2024 онд сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардагдах 279.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.	100%
5	Тавантолгой түлш" ХХК-ийн үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлшийг хэрэглэгчдэд хүргэх, үйлчлэх ажиллагааг нийслэлд шилжүүлэх асуудлыг судал, зохих арга хэмжээ авах.	"Тавантолгой түлш" ХХК-ийн Хэрэглэгчдэд үйлчлэх төвийг нийслэлд шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга боловсруулсан 2023.09.22-ны өдрийн а/3153 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн бөгөөд уг асуудлыг Засгийн газрын 2023.09.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, Засгийн газрын 39 дүгээр тэмдэглэлээр Хэрэглэгчдэд үйлчлэх төвийг нийслэлийн харьяанд шилжүүлэх шийдвэр гарсан. Нийслэлийн Засаг даргын 2023.10.20-ны өдрийн А/1232 дугаар захирамжаар Хэрэглэгчдэд үйлчлэх төвийг нийслэлд шилжүүлэх асуудлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, нийслэлд шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, тус төвийг нийслэлийн харьяанд шилжүүлээд байна.	100%
6	"Энержи ресурс" ХХК-тай байгуулсан түүхий эд (мидлинг) нийлүүлэх гэрээний хугацааг сунгах асуудлыг хоёр талын байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд зохих журмаар шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах.	"Энержи ресурс" ХХК болон "Тавантолгой түлш" ХХК-ийн хооронд 2018.08.01-ний өдөр байгуулсан "Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зориулалтаар шахмал түлш үйлдвэрлэх баяжуулсан эрчим хүчний нүүрс нийлүүлэх тухай" ЕР-18-180 тоот гэрээний хугацааг 2023 оны 12 дугаар сарын 31- ний өдөр хүртэл сунгасан.	100%
7	Сайжруулсан шахмал түлшний түүхий эд (мидлинг)-ийн төмөр замын тээвэрлэлтэд хөнгөлөлт үзүүлэх, тээвэрлэлтийн вагоны тоог нэмэгдүүлэх асуудлыг зохих журмын	Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт болон "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат нарт сайжруулсан шахмал түлшний түүхий эд мидлингийн тээврийн вагоны тоог нэмэгдүүлэх тухай 2023.08.11-ний а/2644 тоот албан бичгийг Эрчим	100%

	дагуу шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	хүчний сайдаас хүргүүлсэн бөгөөд 2023 оны 8 дугаар сараас мидлинг тээврийн вагоны тоо 215-аас 265 хүртэл нэмэгдүүлсэн.	
8	Эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөрөнгө оруулалтыг татах асуудлын хүрээнд төр, бизнес эрхлэгчдийн зөвлөлдөх уулзалтыг улирал тутам зохион байгуулах боломжийг судалж, зохих арга хэмжээ авч ажиллах.	Эрчим хүчний яам, Монголын эрчим хүчний засаглал хөтөлбөр, Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэгчдийн холбоо ТББ хамтран, "Шинэ эрчим хүч" олон улсын хурлыг 2023 оны 09 дүгээр сарын 27, 29-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулж, гадаад дотоодын банк санхүүгийн болон олон улсын хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгчид, хөрөнгө оруулагчдын төлөөлөл, дотоодын төрийн болон бизнес эрхлэгчдийн төлөөлөл 280 гаруй хүн оролцсон. АНУ-ын ЭСЯ-наас Эрчим хүчний яамтай хамтран эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор "Шинэ эрчим хүч- эмэгтэйчүүд" форумыг 10 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, 100 орчим төлөөлөгч ололцсон. Монгол-Хятадын экспло арга хэмжээний хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотноо 2023 оны 09 дүгээр сарын 03-09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Хятад-Монголын төрийн өмчит аж ахуйн нэгжийн шинэчлэл, хөгжил форум"-д төлөөлөл оролцуулж, Монгол улсад зохион байгуулагдсан үзэсгэлэн болон зөвлөлтөөнд ТНБД тэргүүтэй оролцож, эрчим хүчний хамтын ажиллагааны төслүүдийн талаар харилцан санал солилцсон.	70%
9	Эрчим хүчний сэргэлтийн хүрээнд эрчим хүч, хувийн хэвшил, малчид, ахмад, хот хөдөөгийн тэнцвэр зэрэг сэдвээр олон улсын түвшний хурлыг зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах.	Өмнөговь аймагт 2023 оны 09 дүгээр сарын 28, 29 -ний өдөр зохион байгуулагдсан "Invest Gobi-2023", Дорнод аймагт мөн өдрүүдэд зохион байгуулагдсан хөрөнгө оруулагчдын форумд Эрчим хүчний сэргэлтийн талаар танилцуулж, мэдээллийг хүргэв.	100%

---oOo---